## Нэгдүгээр хэсэг. СОНГОХ ДААЛГАВАР

***Санамж:*** Нэгдүгээр хэсэг нь 50 сонгох даалгавартай нийт 76 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье

1. Газарзүйн зургийг ажиглан ЗУ114$^0$-ийн шугамыг дайран өнгөрч буй аймгуудыг сонгоно уу. **/1 оноо/**




A. Хэнтий, Дорноговь B. Дорнод, Сүхбаатар C. Хөвсгөл, Архангай
D. Говь-Алтай, Ховд E. Архангай, Булган

2. Атлантын далайн талбайн хэмжээ жил болгон нэмэгдэж байгаа нь тектоникийн хавтангуудын ямар хөдөлгөөний үр дүн бэ? Зургийг ажиглан зөв хариултыг сонгоорой. **/1 оноо/**




A. Еврази-Номхон далай, шилжин зөрөх
B. Энэтхэг Австрали-Африк, холдон салах
C. Энэтхэг Австрали-Еврази, ойртон нийлэх
D. Африк – Өмнөд Америк, холдон салах
E. Еврази-Хойд америк, ойртон нийлэх

3. Дараах үзүүлэлтүүдийн аль нь хөгжингүй орны шинж вэ? **/1 оноо/**
   A. Шинээр аж үйлдвэржиж буй B. Хүн амын хэт өсөлттэй
   C. Нийгмийн дундаж давхаргын эзлэх хувь их D. Нийгмийн тэгш бус байдал тод
   E. Түүхий эдийн гол нийлүүлэгч
4. 2017 оны байдлаар Монгол улс дэлхийн 189 оронтой дипломат харилцаатай байна. Энэ нь даяаршлын ямар хэлбэр бэ? **/1 оноо/**
   A. Ардчиллын даяаршил B. Эдийн засгийн даяаршил C. Нийгмийн даяаршил
   D. Соёлын даяаршил E. Улс төрийн даяаршил
5. Аж үйлдвэрийн салбаруудыг анхдагч, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч гэсэн хэв шинжүүдэд ангилдаг. Дөрөвдөгч аж үйлдвэрийн хэв шинжид хамаарахыг нь сонгоно уу. **/1 оноо/**
   A. Судалгаа шинжилгээ B. Боловсруулах үйлдвэр C. Хөдөө аж ахуй
   D. Үйлчилгээний салбарууд E. Түүхий эд олборлох салбар
6. Жилийн турш халуун, хуурай агаар бүхий их даралтын мужууд орших бүслүүр аль нь вэ? **/1 оноо/**
   A. Дулаан бүслүүр B. Халуун бүслүүр C. Экватор орчмын бүслүүр
   D. Хүйтэн бүслүүр E. Сэрүүн бүслүүр
7. Монгол улс 150 тэрбум гаруй тн нүүрсний нөөцтэй, 300 гаруй орд илэрцтэй. Тавантолгойн нүүрсний орд нь эртний төрмөлийн аль галавт үүссэн бэ? **/1 оноо/**
   A. Цэрд B. Карбон C. Юра D. Перм E. Триас
8. Янз бүрийн гадаргын ойлгох чадвар өөр өөр байдаг. Дараах өгөгдлүүдээс хамгийн бага альбедотойг нь сонгоно уу **/1 оноо/**
   A. Ой мод B. Шинэ цас C. Элс D. Зузаан үүл E. Цөл
9. Тодорхой температуртай агаарт агуулагдаж болох усны уурын дээд хэмжээг юу гэж нэрлэдэг вэ? **/1 оноо/**
   A. Үнэмлэхүй чийг B. Харьцангуй чийг C. Шүүдэр цэг
   D. Дутмаг чийг E. Үнэмлэхүй чийгийн багтаамж

10. Голын уналыг уртад нь харьцуулсан үзүүлэлтийг юу гэдэг вэ? **/1 оноо/**
    A. Голын хэвгий B. Голын унал C. Голын хөндлөн зүсэлт
    D. Голын дундаж гүн E. Голын сүлжээний нягтшил

11. Зурагт 11-ийн тоогоор тэмдэглэсэн урсгалыг нэрлэнэ үү **/1 оноо/**




A. Гольфстримийн урсгал B. Бразилийн урсгал C. Куросиогийн урсгал
D. Перугийн урсгал E. Саргассын урсгал

12. Хөрсний доройтол, элэгдэлд нөлөөлөх БАЙГАЛИЙН хүчин зүйлийг сонгоно уу **/1 оноо/**
    A. Мал аж ахуй эрчимжих B. Усалгаатай талбай нэмэгдэх
    C. Дэд бүтэц тэлэх D. Аж үйлдвэржилт нэмэгдэх
    E. Шар усны үерт автах

13. Япон улс 127.000.000 хүн амтай, газар нутгийн хэмжээ 380.000 $км^2$ бол хүн амын нягтшил хэд байх вэ? **/1 оноо/**
    A. $1км^2$-т 434 хүн ноогдоно
    B. $1км^2$-т 134 хүн ноогдоно
    C. $1км^2$-т 234 хүн ноогдоно
    D. $1км^2$-т 334 хүн ноогдоно
    E. $1км^2$-т 534 хүн ноогдоно

14. Зургийг ажиглан растерийн оновчтой дүрслэлийг сонгоно уу **/1 оноо/**




A.


B.


C.


D.


E.


15. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Газарзүйн мэдээллийн систем нь компьютерт суурилсан буюу тоон технологи орон зайн.......…………ийг ашиглан газарзүйн зураг, газарзүйн мэдээллийн загварчлалыг боловсруулдаг технологийн шийдэл юм.**/1 оноо/**
    A. байршил B. өгөгдөл C. технологи D. тандалт E. зураглал

16. Дараах улсуудыг орших газартай нь зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. **/1 оноо/**

| Орших газар | Орших улсууд |
|---|---|
| 1. Арал | а. Хойд Солонгос |
| 2. Хойг | б. Австрали |
| 3. Эх газар | в. Куба |

A. 1б, 2а, 3в B. 1б, 2в, 3а C. 1а, 2б, 3в D. 1в, 2а, 3б E. 1а, 2в, 3б

17. Даяаршлын ЭЕРЭГ талыг дурдсан хариултыг сонгоорой **/1 оноо/**
    A. Ахуй, хэл соёл уусах B. Мэдээ, мэдээлэл солилцох
    C. Улс орнуудын хөгжлийн ялгаа ихсэх D. Түүхий эдийн үнэд сөрөг нөлөөтэй
    E. Цөөхөн улс орон улам хүчирхэгжих

18. Зургийн агуулга юуг илэрхийлж байгааг хариултаас сонгоно уу **/1 оноо/**




A. Соёлын ялгаа B. Технологийн дэвшил C. Зам тээвэр
D. Хүн амын нягтшил E. Уур амын өөрчлөлт

19. Зуучлалаар дамжуулан орон сууц худалдаж авахаар болжээ. Ямар салбараар үйлчлүүлэх бэ? **/1 оноо/**
A. Харилцаа холбоо B. Даатгалын үйлчилгээ C. Үл хөдлөх борлуулалт
D. Тусгай үйлчилгээ E. Нийтийн үйлчилгээ

20. Эх дэлхийдээ ээлтэй, ногоон амьдралын хэв маягтайг нь сонгоно уу. **/1 оноо/**
A. Нэг удаа ашиглах бараа сонгодог B. Хаягдлыг тооцохгүй хэрэглэдэг
C. Дахин ашиглах бүтээгдэхүүн сонгодог D. Усыг хэтрүүлэн ашигладаг
E. Хяналтгүй эрчим хүч хэрэглэдэг

21. Дараах хариултаас доод мантийг зөв тодорхойлсныг нь сонгоорой. **/1 оноо/**
A. Даралт хамгийн өндөр, хатуу бодисоос тогтоно.
B. Нягт бага, сийрэгжсэн, уян налархай шинжтэй.
C. Нягт их, 900-2900 км-ыг хооронд тархана.
D. 2900-5150 км-ын хооронд тархаж, долгионы хурд удааширна.
E. Нягт багатай, тунамал, боржин, хүрмэн чулуун үе давхаргатай.

22. Магмын чулуулаг аль нь болохыг сонгоорой. **/1 оноо/**
A. Боржин B. Гнейс C. Гантиг D. Кварцит E. Хайрга

23. Газарзүйн зурагт Амазон мөрний байршлыг тодруулан харуулжээ. Хаанаас эх авч, хаана цутгаж байна вэ? **/1 оноо/**
A. Кордильерын нуруунаас эх авч Номхон далайд цутгана.
B. Гималайн нуруунаас эх авч Номхон далайд цутгана.
C. Андын нуруунаас эх авч Номхон далайд цутгана.
D. Кордильерын нуруунаас эх авч Атлантын далайд цутгана.
E. Андын нуруунаас эх авч Атлантын далайд цутгана.



24. Биомандлын хил хязгаарыг тогтоодог үндэслэл юу болохыг нэрлээрэй. **/1 оноо/**




A. Үржил шим сайтай хөрсний тархалт
B. Органик гаралтай чулуулгийн тархалт
C. Амьдрах нөхцөл, амьдралын ул мөр
D. Ашигт малтмалын тархалт байршил
E. Ургамлын бүрхэвч тархалт ул мөр

25. 1800 оны эхэн хүртэл дэлхийн хүн амын тоо 1 тэрбумд хүрдэггүй байв. Графикийг ажиглан дараах өгөгдлүүдээс хэдэн оны хооронд хүн амын өсөлт хамгийн их байгааг сонгоно уу **/2 оноо/**




A. 1900-1950
B. 1850-1900
C. 1800-1850
D. 1950-2000
E. 1700-1750

26. Хүн амын суваргыг ажиглан хэдээс хэдэн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна вэ? **/2 оноо/**




A. 30-34 насны
B. 25-29 насны
C. 35-39 насны
D. 40-44 насны
E. 5-9 насны

27. Цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй. Монгол улсаас Хятад улс руу жилд дунджаар 50 сая орчим тн ..........................тээвэрлэдэг. Үүний дийлэнх нь ....................тээврийн төрлийг ашигладаг байна. **/2 оноо/**

A. зэсийг, цахилгаан
B. алтыг, дамжуулах хоолойн
C. газрын тосыг, усан замын
D. байгалийн хийг, агаарын
E. нүүрсийг, авто замын

28. Газар хөдлөлтийн хүч, хугацаа давтамжийг сейсмографийн тусламжтайгаар тогтоож болдог. Зургийг ажиглан хэддэх секунтээс эхлэн чичирхийлэл тогтворжсоныг сонгоно уу. **/2 оноо/**




A. 25 дахь секунтээс
B. 15 дахь секунтээс
C. 12 дахь секунтээс
D. 10 дахь секунтээс
E. 9 дахь секунтээс

29. Зургийг ажиглан мезосфер /дунд мандал/-ийн давхаргыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой. **/2 оноо/**




A. Үүлгүй. Озоны давхарга оршино.
B. Цаг агаарын бүх үзэгдэл явагддаг
C. Температур буурч, салхины хурд 150м/сек хүрнэ.
D. Температур нэмэгдэж 1500$^{0}$C хүрнэ.
E. Ионжилт их, устөрөгч илүү зонхилно.

30. 2005 оны 8 сарын Катрина хар салхины үеэр 1836 хүн амь насаа алдан, 108 тэрбум ам/долларын хохирол учирчээ. Зургийг ажиглан хар салхины үргэлжилсэн өдрүүд болон даралтыг ажиглан салхины хүч суларсан өдрүүдийг сонгоно уу **/2 оноо/**




A. 29-30-ны өдрүүд
B. 30-31-ны өдрүүд
C. 24-25-ны өдрүүд
D. 25-26-ны өдрүүд
E. 26-27-ны өдрүүд

31. Өвөрхангай аймгаас Хятад руу явбал хамгийн ойрын, улирлын чанартай боомт аль нь вэ? **/2 оноо/**




A. Шивээхүрэн-Сэхэ B. Булган-Такашикен C. Цагааннуур-Ташанта
D. Ханги-Мандал E. Ханх-Монд

32. Google earth программын зурагт 4-ийн тоогоор тэмдэглэсэн командыг идэвхжүүлээд цаг агаарын ямар элементийг харж болох вэ? **/2 оноо/**




A. Үүлшилт
B. Температур
C. Хур тунадас
D. Салхи
E. Даралт

33. Доорх зургийг ашиглан Дэлхий ба Ангараг гаригуудын хоорондын зайг одон орны нэгжээр /о.о.н/ илэрхийлээрэй./1 о.о.н = Нар дэлхий хоёрын хоорондох зай/ **/2 оноо/**




A. 0.72 о.о.н B. 0.62 о.о.н C. 0.52 о.о.н D. 0.82 о.о.н E. 0.92 о.о.н

34. Нар, дэлхий, сар гэсэн дараалллаар нэг шулуун дээр давхцах үеийг юу гэж нэрлэх вэ? **/2 оноо/**
A. Сарны фаз B. Сар хиртэлт C. Битүүн D. Нар хиртэлт E. Тал сар

35. Зургийг ажиглан 4 ба 7-ийн тоогоор тэмдэглэгдсэн хаант засаглалтай Ази тивийн улсыг сонгоно уу. **/2 оноо/**




A. Испани, АНЭУ B.Брунэй, Испани C.Тайланд, Япон
D. Сауд Араб, Непал E.Ватикан, Норвег

36. Хүн амын ихэнх нь англи хэлтэй, протестант шашинтай, сагсан бөмбөг тоглож, рэйп хөгжим сонсож, түргэн хоолны газраар үйлчлүүлдэг бол соёлын газарзүйн тархалтын ямар мужид хамаарах вэ? **/2 оноо/**
A. Араб исламын B. Зүүн Ази C. Хойд америкийн
D. Словян ба оросын E. Зүүн өмнөд азийн

37. Дараах хотуудаас ЕВРОП тивийн тэргүүлэх зэрэглэлийн альфа хотыг сонгоорой. **/2 оноо/**
A. Токио B. Нью-Иорк C. Лондон D. Лос-Анжелес E. Хонконг

38. Малчин Б–ийнх 12 үхэр, 8 адуу, 20 ямаа, 55 хонь нийт 95 толгой малтай ба бэлчээрийн даацын хуваарилалт хийхийн тулд бүх сүргийг хонин толгойд шилжүүлэн тооцоолно уу. /1 үхэр=6 хонь, 1 адуу=6 хонь, 1 ямаа=0.9 хонь, 1 хонь=1 хонь/ **/2 оноо/**

A. 182 хонин толгой
B. 133 хонин толгой
C. 173 хонин толгой
D. 103 хонин толгой
E. 193 хонин толгой

*Бодолт:*

39. Дараах графикийг ажиглан интернэтээр мэдээлэл авах хэрэгцээ хамгийн сайн хангагдсан орнуудыг сонгоно уу (*Worldwide Statista, 2020)* **/2 оноо/**




A. Өмнөд Солонгос, Хятад
B. Узбекстан, Киргизстан
C. Вьетнам, Тайланд
D. Беларус, Латви
E. Энэтхэг, Пакистан

40. Жуулчид Хамрын хийд рүү аялалд гарахаар болжээ. Рекреацийн ямар нөөцөд тулгуурласан аялал болох вэ? **/2 оноо/**
   A. Хүний гараар бүтээгдсэн сүм хийд, музей
   B. Цэнгэг уст нуур, цаатангуудын аж амьдрал
   C. Эмчилгээний болон рашаан сувилал
   D. Түүхэн хөшөө, хиргисүүр, гэрэлт хөшөө
   E. Эргийн наран шарлага, амралтын газар

41. Тухайн бүсийн онцлогийг зөв тодорхойлсныг нь сонгоно уу **/2 оноо/**



A. Зүүн өмнөд Ази-Тээвэр, шинэ аж үйлдвэржилт
B. Баруун Европ-Аялал жуулчлал, машин үйлдвэрлэл
C. Баруун өмнөд Ази - Газрын тосны олборлолт
D. Зүүн Ази-Технологи, электроник
E. Төв Америк -Хөдөө аж ахуй, газар тариалан

42. Графикийг ажиглаарай. 7-р сард салхины хурд өмнөх оны мөн сараас хэдэн м/сек-ээр нэмэгдсэн байна вэ? **/2 оноо/**




A. 0.5 м/сек
B. 1.0 м/сек
C. 1.5 м/сек
D. 2.0 м/сек
E. 2.5 м/сек

43. Өмнөд Америкийн эх газрын гадаргын байдлыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой. **/2 оноо/**




A. Баруун тал нь уулархаг, зүүн талаараа гадаргын ус их
B. Баруун талаараа тэгш өндөрлөг, гадаргын ус бага
C. Зүүн талаараа цөлөрхөг нуурын тархалт их
D. Баруун талаараа тэгш өндөрлөг
E. Зүүн хойд талаараа уулархаг, гадаргын ус хомс

44. Тасалгааны температур $+10^0$ С байв. Үнэмлэхүй чийгийн хэмжээ 6.3 гр/$м^3$ бол харьцангуй чийгийн хэмжээ хэд байгааг тооцоолно уу /агаарын температур $+10^0$С байх үед чийгийн багтаамж 9.41 гр/$м^3$байна./ **/2 оноо/**
   A. 18.3% B. 80.8% C. 66.9% D. 30.3% E. 15.3%

45. Туркменистан улс дотоодын усны хэрэглээнийхээ 98%-ийг импортоор авдаг. Үүнд нөлөөлсөн БАЙГАЛИЙН хүчин зүйлийг сонгоорой. **/2 оноо/**
   A. Усны зохисгүй хэрэглээтэй B. Хүн амын усны хэрэглээ өндөр
   C. Хөвөнгийн тариалалтад ус их хэрэглэнэ D. Дотоодын мөргөлдөөн зөрчил их
   E. Газар нутгийн дийлэх цөл тархсан

46. Хөдөө аж ахуйн салбарт хөрсний үзүүлэх үүрэг нь юу вэ? **/2 оноо/**
   A. Уур амьсгалыг тэнцвэржүүлдэггүй B. Гүний усанд нөлөөлдөггүй
   C. Түүх соёлын өв тээгч болдог D. Хүнс тэжээл, үр тарианы эх үүсвэр болдог
   E. Агаарын температурт нөлөөлдөггүй

47. Google earth-ийн зургийг ажиглан 24-р сургууль Улсын их дэлгүүрээс аль зүгт байгааг тодорхойлоорой. **/2 оноо/**




A. Баруун урд B. Зүүн хойд C. Баруун хойд D. Зүүн E. Хойд

48. Тус улс нь 4.000.000 хүн амтай, хүн амын ердийн өсөлт нь 2% бол хэдээр нэмэгдсэнийг тооцоолоорой. **/2 оноо/**
   A. 20000
   B. 48000
   C. 80000
   D. 2000
   E. 40000

*Бодолт:*

49. Сидней хотын агаарын температур +82$^0$F, Сингапур хотын агаарын температур +30$^0$C байв. Хоёр хотын агаарын температурын зөрүү цельсийн хуваариар хэд болохыг тооцоолоорой. **/2 оноо/** *($^0$F-32)/9*5=$^0$C*
A. 8.5$^0$C B. 5.2$^0$C C. 2.3$^0$C D. 22.5$^0$C E. 12.5$^0$C

50. Хүснэгтэн мэдээллийг ашиглан Монгол улсын эрчим хүчний усны хэрэглээ дэлхийн дунджаас хэдэн %-иар илүү байгаа шалтгааныг тодорхойлж тооцоолол хийнэ үү. **/2 оноо/**

| № | Салбар | Дэлхийн дундаж/%/ | Монгол улсын дундаж/%/ |
|---|---|---|---|
| 1 | Хөдөө аж ахуй | 67 | 28 |
| 2 | Хүн амын унд, ахуй | 9 | 16 |
| 3 | Эрчим хүч | 7 | 25 |
| 4 | Үйлдвэрлэл | 11 | 8 |
| 5 | Уул уурхай | 2 | 22 |
| 6 | Бусад | 4 | 1 |
| Нийт | | 100 | 100 |

A. Нарны эрчим хүч голлоно. Дэлхийн дунджаас 10%-иар бага
B. Усан цахилгаан станц голлоно. Дэлхийн дунджаас 25%-иар их
C. Салхины эрчим хүч голлоно. Дэлхийн дунджаас 25%-иар бага
D. Дулааны цахилгаан станц голлоно. Дэлхийн дунджаас 18%-иар их
E. Атомын эрчим хүч голлоно. Дэлхийн дунджаас 7%-иар их

## Хоёрдугаар хэсэг. НӨХӨХ ДААЛГАВАР

**Санамж:** Даалгавруудын хариултыг бөглөхдөө хариултын хуудасны 2-р хэсгийг бөглөх заавартай сайтар танилцаарай. Зургийг бодит хэмжээгээр өгөөгүй гэдгийг санаарай.

2.1 Зургийг ажиглан дэлхийн хөдөлгөөний даалгавруудыг гүйцэтгээрэй. **/6 оноо/**




I. Дэлхий 3-ын тоогоор тэмдэглэгдсэн байршилд байх үед хойд хагаст улирал болон нарнаас алслагдсан зай ямар байхыг тодорхойлно уу **/a/ /2 оноо/**

1. Өвөл, 147 сая км 2. Намар, 150 сая км 3. Хавар, 150 сая км
4. Жилийн турш, 150 сая км 5. Зун, 152 сая км

II. 4-ийн тоогоор тэмдэгдсэн байрлал буюу 9 сарын 21-нд ХӨ$38^0$-д тусах нарны өндрийг тооцоолно уу **/bc/** **/2 оноо/** *H=90-φ*

III. Өгүүлбэрийг нөхөөрэй.
Дэлхийн........................эргэх хөдөлгөөний үр дүнд...........................хэмнэл үүсдэг.
**/d/** **/2 оноо/**

1. тэнхлэгээ, жилийн 2. нарыг, сарыг 3. сарыг, хоногийн
4. тэнхлэгээ, хоногийн 5. нарыг, хоногийн

2.2 Монгол улсын 2023-2024 оны нислэгийн тоон мэдээллийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй. **/6 оноо/**

I. Улаанбаатараас хамгийн олон хүн зорчдог бета зэрэглэлийн хот аль нь вэ? **/a/ /2 оноо/**




1.Фукуок 2.Токио 3.Бээжин 4.Истанбул 5.Сөүл

II. Орон нутгийн нислэгийн тоон графикийг ашиглан өмнөх оноос хэдэн хувиар өссөнийг тооцоолоорой. **/bc.d/ /2 оноо/**




III. Автобус 150 км-ын зайтай хоёр хотын хооронд 31 хүн тээвэрлэсэн бол зорчигч эргэлтийг олоорой. **/efgh/ /2 оноо/**

2.3 Гадаргыг өөрчилдөг эндоген ба экзоген хүчин зүйлстэй холбогдох даалгавруудыг гүйцэтгээрэй **/6 оноо/**

I. Зургийг ажиглан Африкийн хавтанд хамаарагдах газар нутгийг нь сонгоно уу **/a/ /1 оноо/**




1.Атлантын далай Японы арал
2.Атлантын далай, Мадагаскар
3. Атлантын далай Гренланд арал
4. Энэтхэгийн далай, Тасман арал
5. Карибын тэнгис, Панамын суваг

II. Эндоген ба экзоген үйл явцуудыг зөв харгалзуулна уу. **/5 оноо/ [b][c][d][e][f]**

| | | | |
|---|---|---|---|
| b | Газар хөдлөлтийн хүчийг хэмжих нэгж | 1 | Физик өгөршил |
| c | Гадарга нурах, бутрах, ус салхинд элэгдэх | 2 | Давхраат галт уул |
| d | Тайван ба дэлбэрэлтийн үе ээлжлэн явагддаг | 3 | Рихтерийн магнитууд |
| e | Амьтан ургамал элдэв бактерийн үйл явцад чулуулаг задарч бутрах өөрчлөгдөх | 4 | Синклинал |
| f | Гадаргын атирааны хотгор хэлбэр | 5 | Органик өгөршил |

2.4 Хүснэгтэн мэдээллийг ашиглан дараах даалгавруудыг гүйцэтгээрэй. **/6 оноо/**

| № | Далайн үзүүлэлтүүд | А. Номхон далай | Б. .Атлантын далай | В. Хойд мөсөн далай | Г. Энэтхэгийн далай | Д. Өмнөд далай |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Талбай /сая.км2/ | 165.2 | 92.4 | 14.0 | 73.5 | 15.9 |
| 2 | Дундаж гүн /м/ | 4280 | 3646 | 1038 | 3741 | 4500 |
| 3 | Температур /$^0$C/ | 28.3 | 21.5 | -1.2 | 25.2 | 2.5 |
| 4 | Давсжилт /%$_0$/ | 34.1 | 33.2 | 32.1 | 34.5 | 34.2 |

I. Далайн усны давсжилтыг илэрхийлэх хэмжигдэхүүнийг сонгоно уу /a/ **/1 оноо/**

1. Паскаль 2. Промиль 3. Метр/куб 4. Процент 5. Франгейт

II. Атлантын далай ба Номхон далайн температурын дундажийг тооцоолоорой. **/bc.d/ /2 оноо/**

III. Дундаж гүний тоон утгыг ихээс бага руу нь эрэмбэлээрэй. **/e/ /3 оноо/**

1. Г-Б-А-Д-В 2. Б-А-Г-Д-В 3. Д-Б-Г-А-В 4. Д-А-Г-Б-В 5. В-Б-Г-Д-А